



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/151

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.15, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1, 1.4.9.2-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Хуульчдын Холбоотой хамтран хүүхэд өсвөр үе, залуучуудад нийгмийн шударга ёс, зөв сэтгэлгээг хөгжүүлэх, амьдрах ухаан, хувь хүний хөгжлийн суурь мэдлэг олгох сургалт, арга хэмжээг 2023 оны 03 дугаар сард зохион байгуулах арга хэмжээний хөтөлбөрийг 1 дүгээр, зардлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 3,600,000 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0270

D:My Doc. Zahiramj. Zasag darga

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ, АМЬДРАХ УХААН,
ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ “РАЦИОНАЛ” СЭТГЭЛГЭЭ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

д/д	Сургалтын хугацаа	Сургалтын сэдэв, агуулга	Сургалтын Оролцогч	Чиглүүлэгч багш
Орхон кино театрт 2023.03.24 Баасан гарагт				
1	14:00-15:30	Эргэцүүлэх сэтгэлгээ арга ба дүрэм - Эргэцүүлэх сэтгэлгээний тухай - Сэтгэлгээний алдаа - Эргэцүүлэх сэтгэлгээний үндсэн дүрэм, Эргэцүүлэн бодох арга барил	Шинэ залуу 200 төрийн албан хаагч	МУИС-ийн ХЗС-ийн багш, хуульч, судлаач Г.Эрдэнэбат
2	15:30-16:10	Mind map: Бодлоо зураглах - Mind map гэж юу вэ? - Ашиглах тохиолдлууд, - Хэрхэн хийх вэ?		Эрх зүйч, судлаач Ж.Эрдэнэханд
	16:10-16:30	Завсарлага		
3	16:30-18:00	Аргумент ойлголт, хэлбэрүүд - Аргументын төрлүүд - Аргумент дэвшүүлэхэд тавигдах шаардлага ба арга зүй		МУИС-ийн ХЗС-ийн багш, хуульч, судлаач Г.Эрдэнэбат
Орхон кино театрт, 2023.03.25 Бямба гараг				
1	09:00-09:40	Хэлэлцүүлэг мэтгэлцээн Хэлэлцүүлэг ба түүний дүрэм - Асуудлын учрыг олох 5 яагаад арга - Хэлэлцүүлэг явуулах 6 малгайн арга - Мэтгэлцээн: арга зүй - Мэтгэлцээний дүрэм	Өсвөр насны 9-12 ангийн 200 сурагч хүүхэд, нийгмийн ажилтан, багш	Хуульч, судлаач О.Мөнхцэцэг
2	09:40-11:00	Логик төөрөгдөл - Логик төөрөгдөл, ойлголт, хэлбэрүүд - Логик төөрөгдлийн төрлүүд		МУИС-ийн ХЗС-ийн багш, хуульч, судлаач Г.Эрдэнэбат
	11:00-11:10	Завсарлага		
3	11:10-12:30	Эргэцүүлэх уншилт-Fact checking - Унших техник ба мэдээлэл хүлээн авахад баримтлах зарчмууд - Literacy: унших арга зүй - Баримтыг нягтлах арга зүй - Мэдээлэл дэх логик төөрөгдлийг нягтлах, хуйвалдааны онол		МУИС-ийн ХЗС-ийн багш, хуульч судлаач Г.Эрдэнэбат

Аймгийн Засаг даргын 2023 оны... дугаар
сарын...-ны өдрийн... дугаар
захирамжийн... дугаар хавсралт

НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ, АМЬДРАХ УХААН,
ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ "РАЦИОНАЛ" СЭТГЭЛГЭЭ СУРГАЛТЫН ЗАРДАЛ

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Өдөрлөгийн арга хэмжээнд шаардагдах үндсэн зардал					
1.	Сургалтын багш нарын хоол, унаа, томилолтын зардал	Хүн*өдөр	3 хүн*2 өдөр	1,200,000	3,600,000
	Нийт дүн				3,600,000

-oOo-